



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-АДАРГА СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/31

Баян-Адарга сум

**Газар эзэмшүүлэх эрхийн дуудлага
худалдаа явуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Газар зохион байгуулалт, гоедези зураг зүйн ерөнхий газрын даргын 2025 оны Аргачлал шинэчлэх батлах тухай А/188 дугаар тушаал, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Сумын 2026 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай 8 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Баян-Адрага сумын Дуурлиг болон Сайхан багт байршилтай 14909 квадрат метр Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор зориулалттай 4 газрын дуудлага худалдааг 2026 оны 04 дугаар сарын 21-ний өдөр цахим хэлбэрээр зохион байгуулсугай.

2. Газрын дуудлага худалдааны анхны үнийг хавсралтаар баталсугай.

3. Дуудлага худалдааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг Баян-Адрага сумын газрын даамал (Т.Очирбат)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын засаг даргын орлогч (Н.Ганбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  О. ДАГВАДОРЖ





Сумын Засаг даргын
2016 оны 08 дугаар сарын 17 ны өдрийн
118 дугаар Захирамжийн хавералт

№	Газрын нэр	Талбай хэмжээ	Анхны үнэ	Зориулалт
1	Хөлийн холбоо	10000	8,000,000	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор
2	Дуурлиг	2209	1,767,200	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор
3	Хатдын өргөө зам дагуу	700	560,000	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор
4	Наран шарлага	1000	800,000	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор